



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 0103

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 33 дугаар зүйлийн 33.1, 33.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.16, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын 2016 онд аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлж, дүгнэхэд шаардлагатай мэдээлэл боловсруулах ажлыг хэсгийг дор дурьдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Дарга:	Аймгийн Засаг даргын орлогч	Г.Хэрлэнчулуун
Гишүүд:	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга	С.Мөнхцэцэг
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	Д.Өнөрцэцэг
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн	С.Энхтоогоо
	Боловсрол, соёл, урлагийн газрын хүний нөөц, бодлого төлөвлөлтийн албаны дарга	Э.Хонгорзул
	Боловсрол, соёл, урлагийн газрын Сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн	Ц.Мөнгөнбаяр
Нарийн бичгийн дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	Г.Лхагвахатан

Хоёр. Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын 2016 онд аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийн талаарх мэдээллийг тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажил, өгсөн үүрэг даалгаврын биелэлттэй уялдуулан холбогдох журмын дагуу 2017 оны 01 дүгээр сарын 15-ны дотор боловсруулж, 01 дүгээр сарын 20-ны дотор танилцуулахыг комиссын дарга /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГДАРГА



Н.ГАНБЯМБА